



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар хөгжил үйлдвэрлэл технологийн парк ОНӨААТҮГ-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СБА-2022/08/НА-СТА-ОНА

<p>Цахим хуудас: www.audit.mn Баруун-Урт сум 2022 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: М.Нарантуяа Утас: 99029193 Цахим хаяг: narantuyam@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Г.Даваа Утас: 99035990 Цахим хаяг: davaag@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: А.Мөнхцэцэг Утас: 99076224 Цахим хаяг: munkhtsetsega@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн орлогын тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	5
3. Аудитын тайлан.....	6
3.1 Ерөнхий зүйл.....	6
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	6
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	6
3.4 Материаллаг байдал.....	7
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	7
Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин	7
3.6 Нягтлан бодох бүртгэлийн бодлого.....	7
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	9
3.8 Аудитын гол асуудал.....	9
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	9
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	10
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	10
4. Аудитын илрүүлэлт	10
4.2 Албан шаардлага	10
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	11
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	11

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НБББББ	Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлогын Баримт Бичиг
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
НӨАТ	Нэмэгдсэн Өртгийн Албан Татвар
ОНӨААТҮГ	Орон Нутгийн Өмчит Аж Ахуйн Тооцоотой Үйлдвэрийн Газар
СТА	Санхүүгийн Тайлангийн Аудит



**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

2022.03.16 № 136
танай _____-ны № _____-т

СҮХБААТАР ХӨГЖИЛ ҮЙЛДВЭРЛЭЛ
ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨААТҮГ-ЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
О.БАТСАЙХАН ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Сүхбаатар хөгжил үйлдвэрлэл технологийн парк ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Сүхбаатар хөгжил үйлдвэрлэл технологийн парк ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Байгууллагын удирдлага санхүүгийн тайлан, тодруулгыг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.НАРАНТУЯА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(2021 оны 12 сарын 31 –ны өдрөөр дуусгавар болсон)

төгрөгөөр

Мөрийн дугаар	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	8,512,191.06	73,707,115.70
1.1.2	Дансны авлага	932,191,390.52	693,584,778.06
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	8,661,667.85	10,815,600.27
1.1.6	Бараа материал	9,626,962.62	19,730,578.57
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	958,992,212.05	797,838,072.60
1.2.1	Үндсэн хөрөнгө	614,500,471.85	580,561,193.91
1.2.2	Биет бус хөрөнгө	95,326,400.00	95,326,400.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	709,826,871.85	675,887,593.91
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,668,819,083.90	1,473,725,666.51
2.1.1.1	Дансны өглөг	164,231,226.52	39,857,037.36
2.1.1.2	Цалингийн өглөг	37,394.00	37,394.00
2.1.1.3	Татварын өр	7,804,748.54	3,654,557.32
2.1.1.4	НДШ-ийн өглөг	10,104,691.27	0.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	182,178,060.33	43,548,988.68
2.1.2	Урт хугацаат өр төлбөр	951,536,222.52	959,940,404.03
2.1.2.2	Нөөц / өр төлбөр/	676,638,966.33	676,638,966.33
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	1,628,175,188.85	1,636,579,370.36
2.2	Өр төлбөрийн нийт дүн	1,810,353,249.18	1,680,128,359.04
2.3.1	Төрийн өмч	95,326,400.00	95,326,400.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	-236,860,565.28	-301,729,092.53
2.3.11	Эздийн өмчийн дүн	-141,534,165.28	-206,402,692.53
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	1,668,819,083.90	1,473,725,666.51

2.2 Аудит хийсэн орлогын тайлан

(2021 оны 12 сарын 31 –ны өдрөөр дуусгавар болсон)

төгрөгөөр

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
4	Түрээсийн орлого	13,076,900.00	20,490,832.03
5	Хүүгийн орлого	3,395,477.72	2,355,440.16
8	Бусад орлого	4,203,526.00	51,859,101.10
10	Ерөнхий ба удирдлагын зардал	60,913,565.22	139,573,900.54
12	Бусад зардал	25,262,545.02	0.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-65,500,206.52	-64,868,527.25
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-65,500,206.52	-64,868,527.25
23	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-65,500,206.52	-64,868,527.25
26	Үйл ажиллагааны нийт үр дүн	-65,500,206.52	-64,868,527.25
28	Нийт орлогын дүн	20,675,903.72	74,705,373.29
29	Нийт зардлын дүн	60,913,565.22	139,573,900.54

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(2021 оны 12 сарын 31 –ны өдрөөр дуусгавар болсон)

төгрөгөөр

	Үзүүлэлт	Өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	95,326,400.00	-171,360,358.76	-76,033,958.76
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00
3	Залруулсан үлдэгдэл	95,326,400.00	-171,360,358.76	-76,033,958.76
4	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00
5	Өмчид гаргасан өөрчлөлт	0.00	0.00	0.00
6	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00
7	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	-65,500,206.52	-65,500,206.52
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00
9	2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	95,326,400.00	-236,860,565.28	-141,534,165.28
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00
11	Залруулсан үлдэгдэл	95,326,400.00	-236,860,565.28	-141,534,165.28
12	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00
13	Өмчид гаргасан өөрчлөлт	0.00	0.00	0.00
14	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00
15	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	-64,868,527.25	-64,868,527.25
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00
17	2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	95,326,400.00	-301,729,092.53	-206,402,692.53

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(2021 оны 12 сарын 31 –ны өдрөөр дуусгавар болсон)

төгрөгөөр

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	81,828,588.19	300,905,605.45
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	57,558,759.67	18,200,440.16
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	0.00	40,000,000.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	24,269,828.52	242,705,165.29
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	86,311,954.81	238,192,001.29
1.2.1	Ажилагсад төлсөн	17,284,918.45	49,630,850.62
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	0.00	22,472,030.27
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	66,553,084.82	6,998,561.52
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	0.00	13,331,593.59
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	0.00	4,881,138.83
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	835,714.00	0.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	37,279.99	11,088,332.68
1.2.9	Бусад мөнгөн зарлага	1,600,957.55	129,789,493.78
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-4,483,366.62	62,713,604.16
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	11,107,846.16	7,266,320.48
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	7,712,368.44	7,266,320.48
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	3,395,477.72	0.00
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	0.00	4,785,000.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	4,785,000.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	11,107,846.16	2,481,320.48
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	3,395,477.72	0.00
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	3,395,477.72	0.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-3,395,477.72	0.00
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	3,229,001.82	65,194,924.64
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	5,385,105.24	8,512,191.06
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	8,512,191.06	73,707,115.70

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүхбаатар хөгжил үйлдвэрлэл технологийн парк ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор А.Мөнхцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Даваа, дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар хөгжил үйлдвэрлэл технологийн парк ОНӨААТҮГ нь 2021 оны санхүүгийн тайлангаа Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 11 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Сүхбаатар хөгжил ҮТП /ОНӨААТҮГ/-ын дүрэмд эрхэм зорилгоо “Шинэ дэвшилтэт технологиор өрхийн болоод импортыг орлох үйлдвэрлэлийг дэмжин бүсчлэн хөгжүүлнэ. Ажлын байрыг нэмэгдүүлж орон нутгийн хөгжлийн тулгуур төв болно.” гэж тодорхойлжээ.

Зорилт:

1. Үйлдвэрлэл технологийн паркийн 1-р бүсийн дэд бүтцийн асуудал улсын төсвийн хөрөнгө оруулалт 1 тэрбум 400 сая
2. Усалгаатай ногоотой хүлэмж улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1 тэрбум
3. 2-р бүстэй холбогдолтой баримт бичиг болон бусад бэлтгэл ажлуудыг хангана
4. Үйлдвэрлэл технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн дагуу тусгай зөвшөөрөл авч хөнгөлөлтөд хамрагдана.

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр

санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар хөгжил үйлдвэрлэл технологийн парк ОНӨААТҮГ нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 60,913.9 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 609.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 426.4 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Байгууллагын үйл ажиллагаа

Сүхбаатар хөгжил үйлдвэрлэл технологийн парк ОНӨААТҮГ нь “Шинэ дэвшилтэт технологиор өрхийн болоод импортыг орлох үйлдвэрлэлийг дэмжин, бүсчлэн хөгжүүлнэ. Ажлын байрыг нэмэгдүүлж, орон нутгийн хөгжлийн тулгуур төв болно” зорилготой үйл ажиллагааг зохион байгуулж байна.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа, гадаад, дотоод худалдаа гэсэн статустай байна. Өмчийг 100 хувь төр эзэмшиж байна.

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Сүхбаатар хөгжил үйлдвэрлэл технологийн парк ОНӨААТҮГ нь Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 05 сарын 19-ны 36 тоот тогтоолоор “Сүхбаатар хөгжил үйлдвэрлэл технологийн парк” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар /ААТҮГ/ нэртэйгээр байгуулагдаж, 2017 оны 06 сарын 06-ээс үйл ажиллагаа эхэлсэн. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дүгээр зүйлд “Орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах бүрэн эрхтэй: ... 5/ орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих;...” гэсэн заалттай нийцэж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

3.6 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Сүхбаатар хөгжил үйлдвэрлэл технологийн парк ОНӨААТҮГ-ын тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган

төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	8,512.2	73,707.1	65,195.0
Авлага	932,191.4	693,584.8	(238,606.6)
Урьдчилж төлсөн тооцоо Татвар, НДШ –ийн авлага	8,661.6	10,815.6	2,154.0
Бараа материал	9,627.0	19,730.6	10,103.6
Үндсэн хөрөнгө	614,500.5	580,561.2	(33,939.2)
Биет бус хөрөнгө	19,326.4	19,326.4	-
Нийт хөрөнгийн дүн	1,668,819.0	1,498,725.6	(170,093.4)
Богино хугацаат өглөг	182,178.0	43,549.0	(138,629.0)
Урьдчилж орсон орлого /УХӨТ/	1,628,175.2	1,636,579.04	8,404.2
Эздийн өмч	(141,534.2)	(206,402.7)	(64,868.5)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,668,819.0	1,498,725.6	(170,093.4)

Арилжааны банкин дахь харилцах дансанд үлдэгдэл 73,707.1 мянган төгрөг болж 65,195.0 мянган төгрөгөөр өссөн нь жижиг дундын үйлдвэрлэлийн санд хүүгийн орлого орж ирснээс шалтгаалсан байна.

Авлага дансны үлдэгдэл 693,584.8 мянган төгрөг болж өмнөх оноос 236,452.8 мянган төгрөгөөр буурсан нь жижиг дундын үйлдвэрлэлийн сангийн зээл болон, хүүгийн төлбөр орж ирсэн, НӨАТ 2,154.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь нөлөөлжээ.

Авлага дансны үлдэгдэл 2018-2021 онд үүссэн зээл болон зээлийн хүүгийн авлага 611,194.4 мянган төгрөгийн авлага байна. Үүнийг ангилан үзвэл: зээлийн авлага 578,243.5 мянга, хүүгийн авлага 22,723.8 мянга, зээлийн хүүгийн алдангийн авлага 10,227.1 мянган төгрөг байна. Тайлант онд авлага өсөхөд нөлөөлсөн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл өмнөх оноос 10,103.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ нь хангамжийн материал /ТЭМ/ худалдан авсан нь материалын данс өсөхөд нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 33,939.2 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь тайлант онд 4,785.0 мянган төгрөг тавилга худалдан авч, 38,724.2 мянган төгрөгийн элэгдлийн зардал нөлөөлжээ.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 138,629.0 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь тайлант онд жижиг дундын үйлдвэрлэлийн сангийн зээл болон, хүүгийн төлбөр төлөгдсөн нь нөлөөлжээ.

Эздийн өмч дансны үлдэгдэл 206,402.7 мянган төгрөг болж 64,868.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээр буурсан нь нөлөөлжээ.

3.6 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Сүхбаатар хөгжил үйлдвэрлэл технологийн парк ОНӨААТҮГ нь байгууллагын санхүүгийн болон үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Сүхбаатар хөгжил үйлдвэрлэл технологийн парк ОНӨААТҮГ нь 2021 онд Аймгийн Засагтай контрактын гэрээ байгуулан ажилласан байна. Контрактын гэрээний хэрэгжилтийг тайлагнасан боловч биелэлтийг дүгнээгүй байна.

Аймгийн Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 01 өдрийн А/134 тоот захирамжаар Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн зардлаас тус газрын цалин, НДШ болон бусад зардалд нийт 40,000.0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосон байна.

Тус байгууллага 2021 оны зорилтот түвшин, үйл ажиллагааны төлөвлөгөө, ашиг орлогын хуваарилалт, бусад эх үүсвэрийг батлуулахаар зохих шатны байгууллагад хүргүүлсэн боловч батлаагүй байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас 2017-2019 онд олгосон зээлийг буцаан төлүүлэх арга хэмжээг зохион байгуулсны үр дүнд 10 зээлдэгчийн зээл, хүүгийн төлбөрт 171,522.9 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэн байна

3.8 Аудитын гол асуудал

Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2017 оны 78 тоот тогтоолоор Сүхбаатар хөгжил ҮТП ОНААТҮГ-ын дэргэд жижиг дунд үйлдвэрийг дэмжих орон нутгийн тусгай санг байгуулсан байдаг. Уг санд орон нутгийн төсвийн орлогоос 891,000.0 мянган төгрөг хуваарилж, ЖДҮ-ийг дэмжих чиглэлээр хөнгөлөлттэй зээлийг олгосон. “Сүхбаатар хөгжил-ҮТП” ОНӨААТҮГ олон жил дамжсан өр төлбөртэй, үйл ажиллагааны орлого нь зардлаа нөхөж чаддаггүй нөхцөл байдал үүссэнтэй холбогдуулан тус сангийн хөрөнгөөс зарцуулах эрхийг Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2021 оны 07 тоот тогтоол гарч, олгосон нь дараах хууль, тогтоомжийг зөрчсөн байна. Үүнд:

1. Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.2-т заасны дагуу төсөв батлах, зарцуулах эрхийг гагцхүү аймгийн ИТХ-ын бүх төлөөлөгчдийн хурлын шийдвэрээр баталдаг. Уг сангийн хөрөнгө нь төсвийн нэг бүрэлдэхүүн хэсэг бөгөөд өөр зориулалтаар хөрөнгө зарцуулах тохиолдолд аймгийн ИТХ-аар төсвийг хэлэлцүүлэн батлах ёстой юм. Гэтэл ИТХ-ын тэргүүлэгчдийн 07 тоот тогтоол гарч, сангийн зээлийн эргэн төлөлтөөс “Сүхбаатар хөгжил-ҮТП” ОНӨААТҮГ-ын өр төлбөрийг барагдуулах, үйл ажиллагаанд зарцуулах эрх олгосон нь Төсвийн тухай хуулийг зөрчиж, төсвийн хөрөнгийг зориулалт бус зарцуулсан байна.
2. Жижиг дунд үйлдвэрийг дэмжих орон нутгийн тусгай сан нь Аймгийн засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд авлагаар, “Сүхбаатар хөгжил-ҮТП” ОНӨААТҮГ-ын тайланд урт хугацаат өглөгөөр давхар бичигдэж, бүртгэгдсэн байдаг. Дээрх хууль бус шийдвэрээс шалтгаалан санхүүгийн нэгтгэсэн тайлан болон тус байгууллагын тайланд тусгагдсан өглөг, авлага хаагдах боломжгүй байна. Иймд уг шийдвэр нь УСНББОУС, заавар журмыг зөрчиж байгаа учир зөрчлийн дүнгээр санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг зөрчлөөр авч үзэхээр шийдвэрлэв.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу Сүхбаатар хөгжил үйлдвэрлэл технологийн парк ОНӨААТҮГ-ын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим сайтад 105 мэдээллийг хугацаанд нь 42 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэж байгаа боловч зарим мэдээллийг хангалтгүй байршуулсан гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2,602.0 мянган төгрөгийн төлбөрийн акт, зөрчлийг арилгах 16,200.0 мянган төгрөгийн 2, зорилтот түвшин үйл ажиллагааны төлөвлөгөө, ашиг орлогын хуваарилалт, санхүүжилт цалин хөлсийг батлуулаагүй 1 нийт 3 албан шаардлага, дотоод хяналт, шилэн дансны мэдээлэл, өр, авлага барагдуулах, тооллого хийж тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, бараа материалыг шууд зардалд илэрхийлсэн зэрэг зөрчилд 5 зөвлөмж хүргүүлсэн байна. Шалгагдагч байгууллага өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилтийг 2021 оны 50 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 31,935.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 25,000.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 6,935.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 2 алдаа зөрчилд зөвлөмж хүргүүлээ.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

Жижиг дундын үйлдвэрлэлийн сангийн зээлээс цалингийн зардалд зарцуулсан 25,000.0 мянган төгрөгийг мөнгөн гүйлгээний тайланд орлогоор илүү бүртгэснийг залруулав.

4.2 Албан шаардлага

1. Үндсэн хөрөнгө худалдан авахад 4,785.0, шагнал урамшуулал, ойн медаль, шинэ жилийн арга хэмжээ, нэвтрүүлгийн үйлчилгээнд 2,150.0, нийт 6,935.0 мянган төгрөгийн зардал гаргасан нь Засгийн газрын 2021 оны 43¹ дугаар тогтоолыг зөрчсөн байна.

4.1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоогоогүйгээс санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй хөрөнгө бүртгэлтэй байгаа нь УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлд тусгасан “Хөрөнгийн үлдэх өртөг ба ашиглалтын хугацааг наад зах нь санхүүгийн жил

¹ Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3. “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;”

бүрийн эцэст хянаж үзэх ба хэрэв хүлээлт нь өмнөх тооцооллоос өөр байвал уг өөрчлөлтийг УСНББОУС 3 тооцооллын өөрчлөлтийн дагуу тайлагнана” заалттай нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Үндсэн хөрөнгийн эдийн засгийн нас буюу ашиглах хугацааг тухайн хөрөнгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоож, УСНББОУС-17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлийг мөрдөж ажиллах.

2. Шилэн данстай холбоотой

2.1 Илрүүлэлт:

Шилэн дансны цахим хуудаст 42 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 4 дугаар зүйлийн 4.1.3-т заасан “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” заалт, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”, “иж бүрэн байх”, “үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэх үүрэгтэй албан тушаалтан мэдээллийг тогтоосон хугацаанд нь тогтмол мэдээлэх, хуулийн хэрэгжилтийг бүрэн биелүүлж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 6 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
	Сүхбаатар хөгжил үйлдвэрлэл технологийн парк ОНӨААТҮГ	4	31,935.0	1	25,000.0			2	6,935.0	1	0
Дүн		4	31,935.0	1	25,000.0			2	6,935.0		0
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
	Шилэн дансны мэдээлэл	1						1			
Дүн		5	31,935.0	1	25,000.0	0	0	2	6,935.0	2	0
Нийт дүн											